



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/20

Амардалай

Шүлхий өвчнөөс урьдчилсан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйл 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01 ний өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл, ХХААХҮ-ий сайдын 2023 оны А/02 дугаар тушаал, эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 сарын 02 өдрийн А/251 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/588 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч: Д.Наранцэцэг (МЭТ-ийн Улсын байцаагч)

М. Даваацэрэн (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

Э.Дэлгэрмаа (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

Н.Балданжав (Арвин тэгш баялаг МЭҮН-ийн эмч)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

2. 2023 оны 10 дугаар сарын 17-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтыг зохион байгуулж САЗ-ыг мөрдөн ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтын зар тов мэдээг малчдад хүргэн, бэлэн байдлыг хангуулж мэдрэмтгий малыг бүрэн хамруулах ажлыг Малчид, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтад хамрагдах малчдын байршил газрын маршрут гаргаж, тухай өдрийн дархлаажуулалтын мэдээг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч

(Д.Наранцэцэг)-д ирүүлэхийг багуудад ажиллаж байгаа Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай

5.Дархлаажуулалтын явц, вакцины хадгалалт, тээвэрлэлт, стандартын горим баримтлалд, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг МЭТ-ийн Улсын байцаагч (Д.Наранцэцэг)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ